

A network diagram on a dark blue background. It consists of numerous white and light blue nodes of various sizes connected by thin white lines. One node in the center-left area is highlighted with a red circle and a white border.

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“ИНВЕСКОР ББСБ” ХК
/нэгтгэсэн, аудитлагдаагүй/

InvesCore
САНХҮҮГИЙН ГРУПП



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагчид, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, түншүүд та бүхэндээ 2020 оны жилийн эцсийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа хүргэж байгаадаа баяртай байна. Хэдий Корона вирусын цар тахал дэлхий даяар тархаж, эдийн засаг хүнд байгаа хэдий ч бид санхүүгийн тоон үзүүлэлтүүдээ өсгөн актив хөрөнгийн чанараа сайжруулж, ажлын байрыг бүрэн хадгалж чадлаа.

Дэлхий дахинд халдвар эрчимтэй нэмэгдэж эхлэхэд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бид 2 дугаар сараас эхлэн эрсдэлийн бодлогоо чангаруулж, зээлийн чанарт онцгой анхаарч, анхаарал татсан зээлүүд дээр цаг алдалгүй арга хэмжээ авч эхэлсэн. Мөн аль болох үр ашиггүй зардлыг бууруулах, процессыг автоматжуулах тал руу түлхүү анхаарсан юм.

2020 онд бид 5 салбар шинээр байгуулснаар Улаанбаатар хотод 12 салбар, Эрдэнэт хотод 1 салбар, нийт 13 салбартай боллоо. Мөн Төв Азийн төлөөлөл болох Киргиз улсад анхны салбар охин компаниа байгуулж, Монголын банк бус салбарын түүхэнд шинэ хуудас нэмсэндээ бид баяртай байна. Энэ бол бидний цаашид бусад орнуудын санхүүгийн салбарт хүчээ сорихын эхлэл байх болно.

Байгууллагын санхүүгийн үзүүлэлтүүдийг өмнөх оны эцэстэй харьцуулахад нийт хөрөнгийн дүн 70%-аар өсч 139 тэрбум төгрөг, зээлийн багц 54%-иар өсч 95 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 30%-аар өсч 53 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн хүүгийн орлого 33%-аар өсч 26 тэрбум төгрөг, шимтгэл хураамжийн орлого 129%-р өсч 6 тэрбум төгрөг, цэвэр ашиг 40%-р өсч 12 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Нийт зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 0.2%, чанаргүй зээлийн хувь 2.8% байгаа нь санхүүгийн секторын хэмжээнд хамгийн сайн үзүүлэлт болж байна.



Нийгмийн хариуцлагын хүрээнд бид халдварт өвчний эсрэг үйлвэрлэл, үйлчилгээ явуулж буй үндэсний үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж тэдэнд зориулсан хүүгүй зээл олгосныгоо дурдахад таатай байна. Мөн Ковид-с шалтгаалан бизнесийн үйл ажиллагаа нь саатсан, зогссон олон харилцагч нартайгаа уулзаж, он гарснаас хойш 1576 харилцагчийн 28.6 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулаад байна.

Бид энэ хүнд цаг үеийг аль болох харилцагчиддаа таатай нөхцлөөр дэмжиж, хамтдаа даван туулах уян хатан бодлого барьж ажиллаж байна. Манай ББСБ-ын нийт зээлийн багцын 60-с дээш хувь нь иргэд, жижиг дунд бизнес эрхлэгч нарт олгосон бага дүнтэй зээл байдаг ба нэг зээлдэгчид ногдох дундаж үлдэгдэл 6.0 сая төгрөг, төвлөрлийн эрсдэл бага байдгийн давуу тал гарлаа.

Мөн процессыг автоматжуулах, хүний оролцоог багасгах бодлогын хүрээнд зээл, бусад үйлчилгээг богино хугацаанд шийдвэрлэх Киоск машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлснийг дуулгахад таатай байна.

Бид орон нутгийн ББСБ-уудыг чадавхижуулах, орон нутагт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар харилцан ашигтай хамтын ажиллагаа бий болгох зорилгоор Инвескор Алианс хөтөлбөрийг 2020 оны 8 сард эхлүүлж орон нутгийн хоёр ББСБ-г гишүүнээр элсүүлсэн бөгөөд сургалт зөвлөгөө болон санхүүжүүлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж эхлэлээ.

Цаашид манай байгууллага санхүүгийн секторт үйл ажиллагаа явуулж буй бусад банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол улсын санхүүгийн болон түүнийг дагалдах секторуудын хөгжилд технологи дээр суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдлүүдээр дамжуулан тодорхой хувь нэмэр оруулахыг чухалчлан ажиллах болно.

Хүндэтгэсэн,
“Инескор ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал

Д.Баясгалан


ОНЦЛОГ ДАВУУ ТАЛУУД

- ✓ Хамгийн том банк бус санхүүгийн байгууллага
- ✓ Нээлттэй хувьцаат компани, хувийн секторын хамгийн том IPO
- ✓ Олон улсад үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллага
- ✓ Уламжлалт, Финтек хосолсон бүтээгдэхүүн, үйлчилгээ
- ✓ Бие даасан систем хөгжүүлэлтийн багтай



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

КОМПАНИЙН НЭГДЛИЙН БҮТЭЦ



Инвекор ББСБ ХК нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 9 гишүүнтэй бөгөөд үүнээс 3 нь хараат бус байна.

Үндсэн ажилтны тоо 155-т хүрч 53%-р нэмэгдсэн бөгөөд нийт ажлын байрыг тогтвортой хадгалж өсгөж чадлаа.

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ГОЛ АМЖИЛТУУД

- ✓ “Покет” цахим хэтэвч, төлбөр тооцоо, дижитал зээлийн аппликэйшнийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн ба 2020 оны хамгийн их татагдсан аппликэйшн болсон
- ✓ Хаалттай хүрээнд 8.2 тэрбум төгрөгийн бонд гаргаж амжилттай арилжаалсан
- ✓ Шуурхай зээл бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлсэн
- ✓ Шинээр 5 салбар, 3 охин компанийг байгуулсан
- ✓ “Инвекор ББСБ” ХК нь ББСБ холбооны “Алтан Од” шагналыг хүртсэн
- ✓ “Инвекор Хэтэвч ББСБ” ХХК нь ББСБ холбооны “Алтан Од” шагналыг хүртсэн
- ✓ Хэрэглээний зээлийн үйл ажиллагааг автоматжуулах ухаалаг киоскуудыг нэвтрүүлсэн
- ✓ “Инвекор Хэтэвч ББСБ” ХХК нь Монголбанкнаас цахим мөнгөний зөвшөөрөл авсан
- ✓ Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллах гэрээ байгуулсан
- ✓ Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС)-той санамж бичиг байгуулсан
- ✓ Анхны нээлттэй Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасыг амжилттай гаргасан



ИНВЕКОР АКТИВ

Андеррайтер: InvestCore

АНХНЫ НЭЭЛТТЭЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА **199.67%** БИЕЛЭЛТТЭЙ АМЖИЛТТАЙ ХААГДЛАА

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НОГДОЛ АШИГ

- ✓ “Инвекор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2-р сарын 19-ны өдрийн № А/04-Т тоот тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 17.00 төгрөг буюу нийт 1.2 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн.
- ✓ Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 3-р сарын 23-ны өдөр тогтоосон бөгөөд 2021 оны 4-р сарын 30-ны дотор “ҮЦТХТ” ТӨХХК-ийн дансанд шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нийт 1576 зээлдэгчдийн хүсэлтийн дагуу 28.6 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн гэрээний хугацаа болон нөхцөлд ямар нэг шимтгэл хураамжгүйгээр өөрчлөлт оруулсан.



Ковид-19 цар тахал дэлхий даяар тархсан хүнд цаг үед бид үндэсний үйлдвэрлээ дэмжих, цар тахлын нөлөөллийг бууруулах зорилгоор “Монгол Маск Эрдэнэт” ХХК үйлдвэрт хүүгүй зээл олгосон.



Монголын Хөрөнгийн Зах Зээлийн 30 жилийн ойд зориулсан цогц хөтөлбөрийг дэмжиж “Gold” ивээн тэтгэгчээр оролцож байна.



Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийн үнэрийг дарах Гипон уусмал үйлдвэрлэгч Ногоон Титэм ХХК-д хүүгүй зээл олгосон.




ББСБ-н Холбооноос зохион байгуулсан хандивын аянд нэгдэж Улсын Онцгой Комисс-т 100 сая төгрөгийн хандивын үйл ажиллагаанд оролцсон.

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА




Хувьцааны арилжааны дүнд эзлэх хувь




- ✓ 2020 оны эцсийн байдлаар хувьцааны ханш оны эхнээс **35% хувиар** өсч 2961 төгрөгт хүрсэн байна.
- ✓ IPO хийсэн цагаас хойш хувьцааны ханш нийт **74% хувиар** өссөн амжилттай байна.
- ✓ 2020 онд **6.01 тэрбум** төгрөгийн арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны арилжааны 10 хувийг эзэлж байна.
- ✓ Нийт арилжааны дүнгээр 2020 оны **хамгийн идэвхтэй** арилжаалагдсан хувьцаа болж байна.
- ✓ Зах зээлийн үнэлгээ /2020.12.31/: **212.4 тэрбум төгрөг**
- ✓ Нийт арилжаалагдсан ширхэг (2020): **2,671,229**
- ✓ Нийт арилжаалагдсан дүн (2020): **6.01 тэрбум төгрөг**
- ✓ Өдрийн дундаж дүн (2020): **24.3 сая төгрөг**

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

БОРЛУУЛАЛТЫН СУВАГ



- ✓ 2020 онд бид шинээр 5 салбар байгуулж нийт 13 салбартай болсон бөгөөд 12 нь Улаанбаатар хотод, нэг нь Эрдэнэт хотод үйл ажиллагаагаа явуулж байна.
- ✓ 2021 онд шинээр 8 салбар нээх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд үүний 2 нь орон нутагт, 1 нь дижитал салбар байна.
- ✓ Инвескор Киргиз-н хувьд Бишкек хотод 3 дэд салбар, Ош хотод 1 салбар нээх төлөвлөгөөтэй байна.




- ✓ 2020 оны 3 дугаар улиралд Смарт киоск буюу зээлийн эдийн засагчийн үйл ажиллагааг орлох, ирээдүйд биет салбарыг дангаар орлох зорилготой, технологийн шинэлэг шийдэл бүхий төхөөрөмжийг амжилттай нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.
- ✓ Одоогийн байдлаар худалдааны компаниудтай хамтран бага дүнтэй лизингийн зээлийг киоскоор дамжуулан шуурхай олгож байна.
- ✓ Киоск төхөөрөмжийг нэвтрүүлснээр зээлийн судалгаанд зарцуулах хугацааг 5 дахин бууруулсан.

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ИНВЕСКОР АЛЛИАНС

- ✓ 2020 оны 3 дугаар улиралд “Инвескор Аллианс” хөтөлбөрийг амжилттай эхлүүлсэн.
- ✓ Энэ хөтөлбөр нь орон нутгийн ББСБ-уудыг чадавхжуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх зорилготой ба одоогийн байдлаар Өмнөговь болон Дорнод аймгийн ББСБ нар уг хөтөлбөрийн гишүүнээр элсээд байна.
- ✓ Хөтөлбөрт хамрагдах ББСБ-ууд нь Инвескор ББСБ ХК-тэй мэдлэг, туршлагаа солилцож хамтран ажиллахаас гадна бүтээгдэхүүн үйлчилгээгээ шинэ түвшинд гаргаж хөтөлбөрийн хүрээнд нэгдсэн нэг стандартыг нэвтрүүлэх зорилготой юм.
- ✓ Инвескор ББСБ ХК нь орон нутгийн ББСБ-уудыг чадавхижуулж, шаардлагатай эх үүсвэрийг хангаж ажилласнаар орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.



● Инвескор ББСБ
● Инвескор Аллианс

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

КИРГИЗ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ


- ✓ “Инвекор ББСБ” ХК нь Монголтой соёл болон бусад зүйлээрээ адил төстэй хөгжиж буй орнуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ экспортлох бодлого баримталдаг.
- ✓ Төв Азийн хөгжиж буй орнуудын зах зээлд өөрсдийн амжилт туршлага, финтек бүтээгдэхүүн, санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн давуу талаа ашиглан, салбар компани байгуулах төлөвлөгөөний дагуу Киргиз Улсад хоёр охин компани байгуулж, үйл ажиллагааг нь амжилттай эхлүүлээд байна.
- ✓ Бид 2020 оны 4 сард Киргиз Улсын “Золотой Стандарт банк бус санхүүгийн байгууллагыг худалдан авч эзэмшиж болсон. Хүний нөөцийг шинээр бүрдүүлж, компанийн бодлого журмуудыг шинэчлэн сайжруулсан ба CBS болон LOS системийг амжилттай нэвтрүүлсэн.
- ✓ Мөн Киргиз улсад “Покет КГ” ХХК-г 2020 оны 8 сард байгуулсан. Уг компани нь Финтект суурилсан Покет аппликэйшний Киргизийн зах зээлд зориулсан хувилбарыг хөгжүүлж нэвтрүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр харилцагч нарт цахим хэтэвч, төлбөр тооцоо, онлайн зээлийн үйлчилгээг саадгүй хүргэж эхлэх юм.



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Зээлийн үлдэгдэл, харилцагчийн тоо



- ✓ Нийт зээлийн багц өмнөх оны дүнгээс 54 хувиар өсч 95.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- ✓ Зээлдэгчийн тоо өмнөх оноос 425 хувиар өсч 56,101 болсон байна.
- ✓ Нэг зээлдэгчид ноогдох зээлийн хэмжээ 1.7 сая төгрөг байгаа нь зээлийн эрсдэл буурах гол хүчин зүйл болж байна.

Зээл олголт, эргэн төлөлт (сая төгрөг)




- ✓ 2020 онд зээл олголтын дүн 58 хувиар, эргэн төлөлтийн дүн 75 хувиар тус тус өсчээ.
- ✓ Цар тахлын хүнд цаг үед бид сегментэд суурилсан нээлттэй борлуулалтын тактикийг баримталж ажилласан.
- ✓ Үүний үр дүнд зээлийн эрсдлээ зохистой түвшинд хадгалахын хажуугаар зээл олголт болон зээлийн багцаа өсгөж чадлаа.

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Зээлийн багц, бүтээгдэхүүнээр

■ Дижитал зээл ■ Бизнесийн зээл ■ Хэрэглээний зээл ■ Автомашины зээл



Зээлийн багцын чанар




- ✓ Бизнесийн харилцагч нарт бид зөвхөн санхүүжилт олгохоос гадна сургалт, зөвлөх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж харилцагчаа дэмжиж ажилласаар ирсэн.
- ✓ 2018 оноос хойш нийт 100 гаруй харилцагчдад 4640 цагийн сургалт, зөвлөгөөг үнэ төлбөргүй үзүүлсэн байна.
- ✓ 2021 онд хэрэглээний зээлийг илүү автоматжуулж, ногоон зээл болон ЖДҮ-н санхүүжилтийг онцгой анхаарч идэвхжүүлнэ.
- ✓ “Инвекор ББСБ” ХК-н зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь санхүүгийн секторын хэмжээнд хамгийн бага түвшинд байна.
- ✓ Гол шалтгаан нь зээлийн судалгаа, олголтын үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан, мөн зээлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүний хүчин зүйлийг зохистой түвшинд хязгаарлаж, олон улсын түвшний скоринг системийг ашигладагт оршино.


2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ГОЛ ҮР ДҮН

Цэвэр ашиг (сая төгрөг)




Хүүшимтгэлийн орлого (сая төгрөг)




ROA	8.7%
ROE	23.2%
P/E	17.5
P/B	4.0

Нийт хөрөнгө (сая төгрөг)



Өөрийн хөрөнгө (сая төгрөг)



2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

сая төгрөг	2016	2017	2018	2019	2020
ХӨРӨНГӨ					
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	223	1,104	2,320	5,146	26,581
Хөрөнгө оруулалт	-	-	-	3,600	1,499
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	4,162	17,164	33,627	60,645	92,438
Нийт зээл	4,239	17,554	34,897	61,950	95,354
Эрсдэлийн сан	(78)	(390)	(1,270)	(1,305)	(2,916)
Хүүний авлага	132	695	1,241	1,663	3,972
Авлага	-	-	-	-	4,092
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	-	540	418	1,056	942
Бусад актив	5	40	811	2,310	895
Үндсэн ба биет бус хөрөнгө	29	100	606	7,483	8,957
Нийт хөрөнгийн дүн	4,551	19,644	39,023	81,902	139,376
ӨР ТӨЛБӨР					
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,109	2,508	10,374	19,934	40,178
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	-	7,897	13,867	14,516	13,449
Бонд	-	-	-	-	7,881
Бусад өглөг	44	401	890	7,064	25,306
Нийт өр төлбөрийн дүн	2,152	10,806	25,132	41,513	86,814
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ					
Хувьцаат капитал	2,000	6,097	6,097	16,282	16,282
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	15,378	15,378
Хуримтлагдсан ашиг / (алдагдал)	399	2,741	7,794	8,729	20,902
Нийт өөрийн хөрөнгө	2,399	8,837	13,891	40,389	52,562
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	4,551	19,644	39,023	81,902	139,376

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

сая төгрөг	2016	2017	2018	2019	2020
Хүү болон түүнтэй адилтгах орлого	665	4,476	10,794	19,363	25,686
Хүү болон түүнтэй адилтгах зардал	-	559	1,733	2,108	3,070
Хүүгийн цэвэр орлого	665	3,917	9,061	17,255	22,616
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	23	166	324	2,600	5,957
Нийт хүүгийн бус цэвэр орлого	23	166	324	2,600	5,957
Нийт үйл ажиллагааны орлого	688	4,084	9,385	19,855	28,573
Ажиллагсадтай холбогдолтой зардал	58	329	902	3,001	3,186
Үйл ажиллагааны бусад зардал	221	363	1,503	5,749	7,572
Нийт үйл ажиллагааны зардал	279	692	2,405	8,750	10,758
Ханшийн тэгшитгэлийн орлого (зардал)	112	(17)	78	159	(568)
Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, алдагдал	522	3,375	7,058	11,265	17,247
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	78	312	880	57	3,210
Татварын өмнөх ашиг	444	3,062	6,178	11,208	14,037
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-	(109)	-	16	426
Орлогын албан татвар	45	326	1,124	2,549	2,290
Тайлант үеийн цэвэр ашиг	399	2,628	5,054	8,675	12,173


2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шалгуур үзүүлэлт	Байх ёстой	2018	2019	2020
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-с доошгүй	37.20%	47.60%	39.10%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-с доошгүй	37.20%	47.60%	39.10%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-с доошгүй	35.60%	50.10%	37.30%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-с дээш	9.10%	10.90%	34.50%
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	30%-с хэтрэхгүй	11.90%	9.40%	7.70%
ББСБ-с гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-с хэтрэхгүй	0.00%	0.00%	0.00%
Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	25%-с хэтрэхгүй	0.70%	0.60%	0.60%
Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	10%-с хэтрэхгүй	0.10%	0.10%	0.10%
Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө	50%-с хэтрэхгүй	0.00%	9.70%	12.40%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	+/-40%-с хэтрэхгүй	1.00%	13.90%	18.40%
Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-с хэтрэхгүй	70.90%	46.00%	78.10%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-с хэтрэхгүй	0.00%	0.00%	15.30%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-с хэтрэхгүй	0.80%	7.80%	3.50%

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ



Смарт Лос систем

- ✓ Зээл олголтын үйл ажиллагааг 80% автоматжуулсан
- ✓ Төрийн мэдээллийн ХҮР систем болон Нийгмийн даатгалын мэдээллийн санд холбогдсон
- ✓ Зээлдэгчийн талаар 20 төрлийн мэдээлэл цуглуулдаг
- ✓ Зээлийн үйл ажиллагаанд хүний хүчин зүйлээс хамаарсан эрсдэлийг бууруулсан
- ✓ Зээл олголтын өмнөх болон явцын хяналтыг сайжруулж эрсдэлийг бууруулж байна

Core Banking систем

- ✓ Үндсэн бүртгэлийн систем
- ✓ Харилцагчид зориулсан аппликэйшн
- ✓ Зохицуулагч байгууллагын шаардлагад нийцсэн
- ✓ Эрхийн зохицуулалт, хяналт
- ✓ Мэдээллийн аюулгүй байдал
- ✓ ERP системүүдтэй холбогдсон
- ✓ Дэлгэрэнгүй тайлан мэдээлэл, дашбоард
- ✓ Мэдээллийн нөөцлөлт (backup)

Кредит скорингийн систем

- ✓ Группын зэргэлдээ компани болох “Инвекор Эй Ай Лаб” ХХК хөгжүүлсэн
- ✓ Харилцагчийн үндсэн мэдээллүүд болон сэтгэлзүйн шинж чанаруудад тулгуурлаж шийдвэр гаргадаг
- ✓ Зээлийн эрх тогтоох үйл ажиллагаанд хүний оролцоог байхгүй болгосон
- ✓ Дижитал зээл болон хэрэглээний зээлийн эрх тогтооход ашигладаг

ПОКЕТ ПЛАТФОРМ – ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

pocket

Покет цахим зээлийн үйлчилгээ
14, 30, 60 хоногийн хугацаатай зээл
44,000+ харилцагч

Pocket Loan

Зах зээлд нэвтэрсэн
2020.01.20

pocket

Цахим төлбөр тооцооны
үйлчилгээ
200,000+ харилцагч

Pocket Pay

Зах зээлд нэвтэрсэн
2020.01.20

pocket coupon

Pocket аппликейшны харилцагчдад
зориулсан урамшуулалтай бараа,
үйлчилгээ худалдан авах үйлчилгээ
90%+ амжилттай борлуулалт

Pocket Coupon

Зах зээлд нэвтэрсэн
2020.05.20

pocket ZERO

30-90 хоногийн хугацаанд
2-6 хуваан төлөх боломжтой
худалдан авалтын үйлчилгээ
100+ мерчант

Pocket Zero

Зах зээлд нэвтэрсэн
2020.10.08

2020 оны онцлох бүтээгдэхүүн: Покет зеро 100+ брэнд, 100+ салбар



Түүнчлэн харилцагч нартаа зориулж төлбөрөө хуваалцах, чат, мөнгөтэй дугтуй илгээх, банкны карт холбох үйлчилгээг нэвтрүүлсэн.

ПОКЕТ ПЛАТФОРМ – ГОЛ ҮР ДҮНГҮҮД

2020.01.20 – Албан ёсны нээлт

202,952 Нийт бүртгэлтэй харилцагчийн тоо


44,398 Нийт зээлийн гэрээт харилцагчийн тоо

95,792 Нийт олгосон зээлийн тоо


10.0 тэрбум төг. Зээлийн багц




Нийт бүртгэлтэй харилцагч ('000)




Нийт зээлийн гэрээт харилцагч ('000)



Нийт олгосон зээлийн тоо ('000)



Зээлийн үлдэгдэл (сая төг.)



ПОКЕТ ПЛАТФОРМ – ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зээлдэгчийн байршил	Зээлийн дүн
Улаанбаатар хот, 21 аймаг	20,000 төг – 10 сая.төг
Апп татан авалт	Харилцагчийн үйлчилгээ
500,000+	2 харилцагчийн үйлчилгээний төв, 9+ салбар, хөдөлгөөнт цэг
Мэдээлэл дамжуулах суваг	Хүйсийн харьцаа
<ul style="list-style-type: none"> ✓ Чатбот ✓ Нийгмийн сүлжээ ✓ ХҮТ, салбар ✓ Хөдөлгөөнт цэг 	51:49 эмэгтэй : эрэгтэй

✓ Харилцагчийн үйлчилгээний төв 1, 2



✓ Үзэсгэлэн, арга хэмжээнүүд



175k +
Хүнд мэдээлэл хүргэсэн

✓ Хөдөлгөөнт цэгүүд (олон нийтийн төвүүд)



✓ Мөн дуудлагын төв, харилцагчийн үйлчилгээний төв болон ухаалаг чатбот, нийгмийн сүлжээний хуудсаар дамжуулан зээлийн бүтээгдэхүүн, төлбөр тооцоо, санхүүгийн зөвлөгөө үйлчилгээг орон зай, цаг хугацаа үл хамааран иргэдэд хүргэж байна.

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь доорх гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Үүнд:

- ✓ Хамгаалалтын 3 бүс
- ✓ Дүрэм журмууд
- ✓ Эрсдэлийн хороод



1-Р БҮС

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулах, тэдгээрийг хангаж ажиллах үүрэгтэй.

Газар нэгжүүд

2-Р БҮС

Хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд залруулах, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг 1-р бүстэй хамтарч хэрэгжүүлнэ.

Хууль, эрсдэлийн удирдлагын газар

3-Р БҮС

Хараат бүс эрсдэлийн дүгнэлт, баталгаажуулалтыг гаргана. Байгууллага өөрийн эрсдэлээ хэрхэн үнэлж удирдаж байгааг болон хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн гүйцэтгэлийг үнэлнэ.

Дотоод аудитын газар



InvesCore
САНХҮҮГИЙН ГРУПП

🌐 www.invescore.mn

✉ Info@invescore.mn

☎ 7709-0077